

ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (Сургуулийн 12 ангийн багшид зориулсан сургалтын модуль)

*Н. Мөнхчимэг
(45-р сургууль сургалтын менежер)
hmercitiz@gmail.com/*

Модулийн зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги удирдсан багш нарт АМЧБО үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх, тэдний АМЧБ-ны талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Эрх зүйн баримт бичиг

- БШУ-ны сайдын 2007 “Багшийн ажлын байрны үлгэрчилсэн дүрэм”-д заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ даасан ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг ХГҮА-аар дамжуулан дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх
- БШУ-ны сайдын А/199 дүгээр тушаал “Хичээлээс гадуурх үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр” -ийн долоо дугаар зорилт болох “Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих” ажлын хүрээнд:

А. Суралцах чиглэл, мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх

Б. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:

- 12 ангийн суралцагчдад ахлах ангид сонгон судалж байгаа хичээлээрээ ЭЕШ-нд бэлтгэх, хөтөлбөрөө сонгох, мэргэжлийн боловсрол, сургалт (цаашид МБС)-ын байгууллага болон их дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад анги удирдсан багшийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн суралцагчдын хувьд ангийн багш нь дотны туслагч, зөвлөгч байж, хэрэгцээт мэдээлэллийг цаг алдалгүй өгдөг, сэтгэл зүйн айдсыг даван ухаалгаар шилжилт хийх талаар эцэг эхтэй хамтран дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Анги удирдсан багш нь ажил мэргэжлийн чиг баримжааг үр дүнтэй олгож, хөдөлмөрийн зах зээлийн бодит нөхцөл байдалд нийцүүлэн шинэ залуу үеийг өнөөгийн нийгэмд бэлтгэх нь чухал байна. Хүн бүхэн ажил мэргэжилдээ дуртай, тасралтгүй суралцаж чадвал аз жаргалтайгаар амьдрах цаашлаад нийгмийг сайн сайхан болгож цогцлооход ахлах ангийн сонгон судлах хичээл, хөтөлбөр, МБС, их дээд сургууль болон хөдөлмөрийн зах зээлийн талаар илүү их мэдээлэл авч зөв шийдвэр гаргахад нь нөлөөлж, Монгол Улсын иргэд илүү идэвхтэй, эдийн засгийн хувьд тогтвортой байх нөхцөл бүрдэнэ.
- Сургуулийн зүгээс өөрийн онцлог, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хүний нөөцийн хөгжил, хүүхэд бүрийн авьяас, хүсэл зорилго, сонирхолд тулгуурлан үе шаттайгаар, тасралтгүй хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, өөрийн үнэлгээ хийн дүгнэдэг байх нь чухал.

12 багш нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг

1. Ангийн менежментийн загвараа танхимын болон танхимын бусаар суралцахуй болон багшлахуйгаар ХГҮА-тай уялдуулан төлөвлөх
2. Ангийн менежментийн баг байгуулах / Ахлах ангийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, судлагдахууны багш нар, сурагч, эцэг эхийн төлөөлөл/
3. 8-12 ангийн түвшин тус бүрээр боловсруулсан гарын авлага, цахим хөтөч, мэдээллүүддтэй сайтар танилцаж, ойлгох, өөрийн туршлага, ур чадвараар баяжуулан хэрэгжүүлэх

4. Багш та ажил мэргэжлийн чиг баримжааны талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл дараах онолуудыг судалж үзээрэй. Үүнд:

- Онцлог шинж чанар болон хүчин зүйлийн онол
- Хөгжлийн онол
- Суралцахуй, танин мэдэхүйн онол
- Социологийн онол
- Психодинамик онол
- Хаосын онол

Онолыг илүү дэлгэрэнгүй www.myfuture.mn сайтаас танилцаж болно.

5. Суралцахуйг бүтээлчээр дэмжих, үр өгөөжтэй зохион байгуулахад анхаарах
6. Өөрийн багшлах ур чадвар, арга зүйгээ тасралтгүй хөгжүүлэх
7. Сурагчдынхаа хичээл сонголт, мэргэжил сонголтод сургуулийн удирдлага, эцэг эхтэйгээ хамтран анализ дүгнэлт хийх
8. Төгсөх ангийн сурагчийн нас, сэтгэхүй, онцлогт нь тохируулан судлаач, сэтгэл зүйч, туслагч, зөвлөгч нь байх үүрэг хариуцлагаа ухамсарлах
9. Тухайн сурагчийн авьяас чадварын талаар эцэг эх асран хамгаалагчдад мэдээлэл хүргэж мэргэжлээ сонгох, шийдвэр гаргахад хамтран мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
10. Сурагчдын мэргэжил сонголтын судалгаа, хэрэгцээ сонирхолд үндэслэн их, дээд сургуулийн элсэлт, хөтөлбөр, өөрийн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус байгууллагатай хамтран хөдөлмөр эрхлэх ур чадвар, ажил хөдөлмөртэй танилцах, ажлын байрны сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах
11. Сурагчдын дунд удирдлага, нийгмийн ажилтан, номын санч, мэргэжлийн багш нар, эцэг эхтэй хамтран ажил мэргэжлийн чиглэлээр үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах
12. Төгсөгчийн их, дээд сургуульд элсэлт, ажил, хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл гаргаж үнэлгээ хийх (ажил мэргэжил, үргэлжүүлэн суралцсан байдал, хөдөлмөр эрхлэлт, ажилгүй байдал)

Санал болгож байгаа эдгээр үйл ажиллагаагаар дамжуулан шийдвэр гаргах эгзэгтэй үед нь суралцагчдад дэмжлэг үзүүлэх, оновчтой сонголт хийх, дараагийн шатны сургалт болон ажил хөдөлмөрийн шилжилт амжилттай хийхэд нь бэлтгэх юм.

Агуулга хэрэгжүүлэх сургалтын цагчилсан, төлөвлөгөө:

- Агуулгыг хичээлийн жилийн хугацаанд төлөвлөх хэрэгтэй. Үйл ажиллагааг танхимын ба танхимын бус хэлбэрээр хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажил хоорондын интеграцыг ханган зохион байгуулах нь үр дүнтэй.
- Ахлах анги тухайлбал 12 дугаар анги удирдсан багш нар хамтран ангийн түвшний хөтөлбөрийг боловсруулж болно.

Зорилт	Агуулга	Чадамж	Хугацаа	Танхимын	Танхимын бус
Хувийн менежмент / ойлголттой болох/	Ажил мэргэжил, сургалтын шийдвэртэй холбоотой өөрийгөө таньж мэдэх	Хөгжиж, том болохын хэрээр сэдэл тэмүүлэл, хүсэл эрмэлзлэл өөрчлөгддөгийг ойлгох	2 цаг	-Багш, суралцагчийн гарын авлага ашиглан зохион байгуулах -Сурлагын амжилт	-Цагийн ажил -Сайн дурын үйл ажиллагаа -Ажлын туршлага хуримтлуулах -Гэр бүлийн
	Ажлын ертөнц болон 12 дугаар ангиа төгссөний дараах сургалтын талаар	Сургууль төгссөний дараа боловсрол, сургалт, ажил	2 цаг	-ХГҮА-ны оролцоо	

	ойлголттой болох, түүнийгээ хөгжүүлэх	мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн талаарх боломжуудыг таньж мэдэх		-Ажил мэргэжлийн сорил, судалгаа - Ганцаарчилс ан зөвлөгөө өгөх -Цахим номын сан -вэбсайт -Эцэг эх, төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн байгууллагуу дтай хамтарч ХГҮА зохион байгуулах	үүрэг оролцоо -Найз нөхдийн үүрэг, оролцоо -Чөлөөт цагаараа хийх үйл ажиллагаа -Мэргэжил сурталчлах өдөрлөг -Цахим хөтөч /my future.mn/ -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
	Ажил мэргэжил болон сургалтын шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлсийг мэдэх, хэрхэн удирдахаа мэддэг болох	Ажил мэргэжлийн , сургалтын, орон нутгийн болон нийгэм, эдийн засаг сонголтод хэрхэн нөлөөлдөгийг ойлгох, удирдах	2 цаг		
<p>Багшид зөвлөмж: - Судалгаанаас харахад охид хөвгүүдээс түрүүлж ажил мэргэжлийн төлөвшилтэй болдог. Охид багаасаа ажил мэргэжлийн сонголтын талаар бодож эхэлдэг бөгөөд хийсэн сонголтоо төдийлөн өөрчлөөд байдаггүй. Иймээс охидыг 8 ангиас эхлэн ажил мэргэжлийн төлөвлөлт сайн хийж сурах, ажил мэргэжлийн сонголтондоо “ нээлттэй” хандахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.</p> <p>- Ангийн менежментийн багтай хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим групп ажиллуулах, үнэлгээ, дүгнэлтийг хийж явах.</p>					
Сурах болон ажиллах үйл ажиллагаа /үйл хэрэг болгох /	Богино, дунд, урт хугацааны ажил мэргэжлийн зорилгоо дэвшүүлэх	Зорилгодоо хүрэхэд юу хэрэгтэй болох талаар мэдэх, түүний дагуу гүйцэтгэж чаддаг болох	2 цаг	-Багш, суралцагчи йн гарын авлага ашиглан зохион байгуулах	-Гэр бүл, найз нөхөдтэйгээ зөвлөлдөх - Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээ с зөвлөгөө авах -Холбогдох гарын авлага, цахим мэдээллийн сан ашиглах -Ажлын байраар зочлох - Ажил хөдөлмөр хийж үзэх ажиглалт хийх -Ажил хайх сүлжээ, сайтуудыг мэдэх /biznetwork.m n/ -Ажилд зуучлах байгууллагуу
	Ажил мэргэжлийн болон сургалтын сонголтын дагуу төлөвлөгөө хэрхэн хийхийг сурах, түүнийхээ дагуу сонголтоо хийх	Ажил мэргэжлийн болон сургалтын сонголтынхоо чухлыг нь сонгох, хэрэглэх, үр дагавар, тохиромжтой байдлыг үнэлж чаддаг болох	2 цаг	-Орон нутгийн хөдөлмөри йн хэлтсийн мэргэжилтэ н, сэтгэл зүйчтэй уулзалт ярилцлага хийх, зөвлөгөө өгөх - Төгсөгч, эцэг эх, ажил олгогч, сургалтын байгууллагуу удтай уулзалт, ярилцлага хийх - Өргөдөл, намтар, илтгэл, CV	
	Сонголтынхоо баталгаажуулалт болон хэрэгжилтийг үр дүнтэй удирдах	12 дугаар анги төгсөөд сурах сургалт эсвэл ажлын нөхцлөө хадгалахын тулд аман, бичгийн, нүүр тулсан хэлбэрээр үр дүнтэй харилцах, шилжилтийн үед тохирох стратегийг хөгжүүлэх	2 цаг		

				боловсруулах - Ажлын ярилцлагад бэлтгэх	Д -Орон нутгийн хөдөлмөрийн хэлтэс
	Сонголтоо эргэж харах, дүгнэх чадавхаа бэхжүүлэх	Өмнө хийсэн сургалт, ажил мэргэжлийн сонголтоо эргэн харж дүгнэх, амжилт түвшнийг харгалзан уялдуулж сурч, хөгжих	2 цаг		
Ажил хөдөлмөр эрхлэх / хэрэгжүүлэх /	Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх, түүнээс гарах арга замыг мэдэх	-Суралцагч амьдралын зорилготой байх, өдөр тутмын үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулж ажилгүй нөхцөл байдалд өөрийгөө болон амьдралаа удирдан чиглүүлэх -Дээд боловсрол, МБС-д элсэн суралцах хүсэлт гаргах -Зайны болон цахим сургалтын байгууллагад суралцах хүсэлт гаргах	2 цаг	-Багш, суралцагчийн гарын авлага ашиглан зохион байгуулах -Ротари клуб, худалдаа аж үйлдвэрийн тэнхим, хувиараа аж ахуй, хөдөлмөр эрхлэгчдийг урьж, уулзалт, ярилцлага хийх -	-Ойр дотны хүмүүсийн туршлага, ажиглалт - Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтний зөвлөгөө - Хөдөлмөрийн хууль, гэрээний талаар хүйсийн асуудал, ажлын байрны зан үйл, шаардлагатай танилцах
	Тодорхойгүй нөхцөл байдалд ухаалаг шийдвэр гаргаж сурах		2 цаг		
	Хувиараа ажил хөдөлмөр эрхлэх, бизнестэй байх талаар ойлгох	Хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэх, санхүүгээ удирдах, хөдөлмөрлөх ур чадвараа удирдах, тодорхойгүй нөхцөл байдлыг удирдах	2 цаг	Суралцагчдын дунд мини аж ахуй эсвэл компани үүсгэх, удирдахад дэмжлэг үзүүлэх клубууд ажиллуулах	
Багшид зөвлөмж: Гарын авлагаа суралцагчийн, эцэг эхийн, сорил судалгааны, myfuture.mn цахим гарын авлага болон бусад эх сурвалжтай уялдуулан хэрэглэх хэрэгтэй.			20 цаг	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход эцэг эхийн үүрэг хариуцлага чухал учраас үйл ажиллагааны алхам бүрт эцэг эхтэй нягт хамтран ажиллах хэрэгтэй .	

Ангид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн төлөвлөлт¹
 Дараах хүснэгтэд ангид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийг 12 дугаар ангийн жишээгээр үзүүллээ.

Ангид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн загвар

Хөтөлбөрийн бүрэлдэхүүн	Агуулга
1. Үндэслэл	Яагаад 12 дугаар ангид ажил мэргэжлийн чиг баримжааг хэрэгжүүлэх шалтгаан
2. Зорилтот бүлэг	12 дугаар ангийн бүх суралцагчид
3. Зорилго	Ангийн түвшний зорилго ерөнхий байж болно. Жишээ нь: - ажлын орчин нөхцөл тодорхойгүй үед ирээдүйгээ төсөөлөх, төлөвлөх суралцагчийн чадамжийг сайжруулах - 12 дугаар ангиа төгсөөд сургалтын байгууллагад амжилттай элсэх хүсэлт гаргах чадамжийг сайжруулах - суралцагчийг хөдөлмөр эрхлэлт эсвэл ажилгүйдэлд бэлтгэлтэй байх чадамжийг сайжруулах гэх мэт
4. Зорилт	Зорилт нь зорилгод хэрхэн хүрэхийг тодорхойлно. Жишээ нь хувь хүний болон практикийн чадвар, ур чадвараа удирдан чиглүүлэх, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтийн байгууллагын брошурыг ойлгох, үнэлэх, сургууль төгссөний дараах ажил мэргэжлийн сонголтоо ухаалгаар хийх, сонгосон ажил мэргэжилтэй уялдаатай, хөрвөх боломжтой ажил мэргэжлийн олон янзын боломжийг эрэлхийлэх чадамжийг сайжруулах гэх мэт зорилгын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилттой байж болно.
5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Сургуулийн орчинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Хүснэгт 1-ийг ашиглаарай Сургуулиас гадуурх үйл ажиллагаа: Хүснэгт 1-ийг ашиглаарай
6. Нөөц	Сургуулийн дотоод нөөц: багш, нийгмийн ажилтан, компьютерийн лаборатори, номын сан, интернет холболт, ном, гарын авлага, суралцагч, эцэг эх Сургуулийн гадаад нөөц: Хүснэгт 1-ийг ашиглаарай
7. Үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусах хугацаа	Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлтийн хугацаа болон хичээлийн жилийн амралтыг харгалзан үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхойлсон байна.
8. Үнэлгээ	Явцын үнэлгээ их олон янзын арга байна: хичээлийн жилийн төгсгөлд суралцагчдаас, эцэг эхийн асуулга судалгаа авч болно, багш нар өөрийн үнэлгээ хийж болно. Үнэлгээг хамгийн гол нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдуулж хийнэ.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлээр ахлах ангийн сурагчдын эзэмшсэн мэдлэг чадварт дэмжлэг үзүүлэх

Багш та ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ахлах ангийн суралцагчийн гарын авлагаар сурагчид ямар мэдлэг, чадвар эзэмшиж байгааг судлан танхимын болон танхимын бус аргаар анги удирдсан багш, эцэг эх, сургуулийн удирдлагуудтай хамтран сурагчдад хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар энэ хэсэгт дурдах болно.

12 дугаар анги: / Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

- Сурагчид 11 дугаар ангид хийсэн төлөвлөгөөгөө эргэн харах, сайжруулах
- Дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургуульд өргөдөл гаргах
- Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх
- Тодорхойгүй нөхцөл байдалд шийдвэр гаргах

Дасгал	Сурагчдын эзэмшиж буй мэдлэг	Сурагчдын эзэмшиж буй чадвар	Багшийн үзүүлэх дэмжлэг
1.12 дугаар анги төгссөний дараах ажил мэргэжлийн чиглэл	Сурагч өөрт тохирох 3-5 мэргэжил сонгох	Мэргэжил бүр дээр ямар чадвар эзэмших, энэ нь өөрт байгаа эсэхэд үнэлгээ өгөх	Гарын авлага ашиглан ямар мэргэжилд ямар чадвар шаардлагатайг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
2. Төрийн өмчийн их дээд сургуульд суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших их дээд сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших их дээд сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар судалгаа хийж шийдвэр гаргах	Сургуулийн 12 ангийн сурагчдаас авсан ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн их дээд сургуулийн мэргэжлийн ангийн мэдээлэл хүргэх, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах
3. Хувийн их дээд сургуульд суралцах төлөвлөгөө			
4. Төрийн өмчийн мэргэжлийн боловсролын сургуульд суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших мэргэжлийн боловсролын сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжлээ эзэмших мэргэжлийн боловсролын сургуулийг судлан суралцах хугацаа, гарах зардал, ажлын байрны талаар судалгаа хийж шийдвэр гаргах	Сургуулийн 12 ангийн сурагчдаас авсан ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн ангийн мэдээлэл хүргэх, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах
5. Хувийн мэргэжлийн боловсролын сургуульд суралцах төлөвлөгөө			
6. Төрийн болон хувийн их дээд сургуульд эчнээгээр суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн хүссэн мэргэжлээрээ хэрэв өдрөөр суралцах боломжгүй бол эчнээгээр хэрхэн суралцаж болох талаар мэдээлэлтэй болох	Сурагч өөрийн хүссэн мэргэжлээрээ хэрэв өдрөөр суралцах боломжгүй бол эчнээгээр суралцах талаар судалгаа хийх	Сургуулийн ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн их дээд сургууль, мэргэжлийн сургуультай танилцах, ажлын байрны сургалт хийх, төгсөгчтэй уулзах ажлыг удирдан зохион байгуулах
7. Төрийн болон хувийн мэргэжлийн боловсролын сургуульд эчнээгээр суралцах төлөвлөгөө			
8. Зайн цахим сургалтад суралцах төлөвлөгөө	Сурагч өөрийн сонгосон мэргэжилд тохирох ур чадвараа хөгжүүлэхэд урт богино хугацааны зайн сургалтын талаар мэдэх	Сурагч өөрийн сонгосон мэргэжилд тохирох ур чадвараа хөгжүүлэхэд урт богино хугацааны зайн сургалтын судалгаа хийж хамрагдах	Хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалтыг зохион байгуулах
9. Орон нутагтаа хөдөлмөр эрхлэх	Сурагч өөрийн хүссэн сургууль мэргэжлээ эзэмшихэд тухайн жилдээ амжаагүй тохиолдолд орон нутагтаа юу хийх боломж байгаа талаар мэдэх	Сурагч өөрийн орон нутагтаа ямар хөдөлмөр эрхлэх боломж байгаа судлах	Орон нутгийн хөдөлмөр эрхлэх хэлтэстэй хамтран ажил зохион байгуулах, мэргэжилтэнээс зөвлөгөө авах
10. Хувиараа хөдөлмөр эрхлэх			

11. Өөрийгөө сурталчлан танилцуулах	Өөрийн танилцуулга, өөрийгөө илэрхийлэхэд шаардлагатай мэдлэг мэдээлэлтэй болох	Өөрийгөө илэрхийлэх чадварт суралцах	Хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт үйл ажиллагаа зохион байгуулах
12. Ажилгүй нөхцөл байдлаа удирдах	Олон нийтийн сүлжээ, амьдралын зорилго, зохион байгуулалттай байх мэдлэг ойлголттой болох	Олон нийтийн сүлжээнд байх, амьдралын зорилгоо тодорхойлж зохион байгуулалттай байх чадварт суралцах	

Модуль хэрэгжүүлэх арга зүй:

Энэхүү хэсэгт дээрх дэмжлэг болох үйл ажиллагаагаа ямар арга зүйгээр зохион байгуулах боломжтой талаар мэдээлэл хүргэх гэж байна. Тодорхой нэг ажлыг 12 ангийн сурагчдад өөр өөр арга зүйгээр оролцоонд тулгуурлан зохион байгуулах боломжтой. Иймд 12 ангид ямар арга зүй хэрэглэх талаар дараах хүснэгтэд загвар гарган зөвлөмжлөн хүргэж байна.

Арга зүй	Дэд хэсэг
<ul style="list-style-type: none"> ▪ Сургуульд суурилсан 	<ul style="list-style-type: none"> ▪ Тусгай хөтөлбөр
<p>- Тухайн сургуулийн онцлог, хэрэгцээ, нөөц, боломж дээр тулгуурлан удирдлагатай хамтран багаар ажиллаж, АМЧБ-г сургуулийн орчинд болон сургуулиас гадуур хамгийн үр дүнтэй байдлаар хэрхэн хэрэгжүүлж болох талаар хэлэлцэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах юм.</p>	
<ul style="list-style-type: none"> ▪ Ангид суурилсан 	<ul style="list-style-type: none"> ▪ Бусад хичээлтэй интеграцчлах
<p>- Ангийн менежментийн хөтөлбөрийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилтын хүрээнд ХГҮА-ны танхимын сургалтыг гарын авлагыг ашиглан мэргэжлийн багш нартай хамтран зохион байгуулах, аль дасгалаас эхлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг эхлэх вэ гэдэг нь суралцагчийн хэрэгцээ, өмнөх мэдлэг, чадвараас шалтгаална.</p>	
<ul style="list-style-type: none"> ▪ Мэдээлэлд суурилсан 	<ul style="list-style-type: none"> ▪ Ерөнхий боломжийн талаар ▪ Ажил мэргэжил болон сургалтын талаар илүү тодорхой
<p>- Ажил мэргэжилтэй холбоотой бодитой, чанартай мэдээллүүдийг үндэсний хэмжээний баталгаатай мэдээллийн эх сурвалжуудаас авах хэрэгтэй.</p> <p>Мэдээллийг хэвлэмэл, дүрс бичлэгээр, хэвлэл мэдээллийн хэрэгслээс, цахим, интернетийн орчноос цуглуулж ашиглаж болно. Гол нь бодитой, найдвартай, шинэлэг эсэхэд үргэлж анхаарлаа хандуулж байх хэрэгтэй.</p>	
<ul style="list-style-type: none"> ▪ Туршлага судлахад суурилсан 	<ul style="list-style-type: none"> ▪ Үйлдвэрийн, ажлын байрны орчинд Сургуулийн орчинд Хувь хүнд чиглэсэн дэмжлэг
<p>Энэ үйл ажиллагаагаар суралцагчдад сургуулийн хүрээнд зохион байгуулдаг янз бүрийн үйл ажиллагаанд оролцох, түүнийг удирдах, зохион байгуулах боломжийг олгох хэрэгтэй. Энд зочин урьж илтгэл тавиулах /ихэвчлэн эцэг эхчүүдээс/ ажил мэргэжил сурталчлах өдөрлөг, сайн дурын ажлууд, нийгмийн туст ажлууд, суралцах аялалууд, ажлын байраар зочлох, ажиглалт, судалгаа хийх, биеэр ажил гүйцэтгэж үзэх, төсөл хэрэгжүүлэх, орон нутгийн байгууллага болон аж ахуй нэгж, мэргэжлийн болон их дээд сургуулиудад очиж оюутнуудтай ярилцлага хийх, сургалтын хөтөлбөртэй танилцах, хичээлд суух ажиглах зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх нь суралцах, ажиллах чиглэлээ эртнээс төлөвлөх ач холбогдолтой.</p>	

<ul style="list-style-type: none"> Ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> Зөвлөгөө, туслалцаа Үйл явцтай нь холбох/ зуучлах
<p>Суралцагчдад нийлмэл төвөгтэй мэдээллийг боловсруулах, өөрийн үнэлгээ хийхэд дэмжлэг туслалцаа хэрэгтэй болдог ба доорх хоёр хэлбэрээр дэмжлэг туслалцаа үзүүлж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Эхний хэлбэр нь тухайн суралцагчийг хамгийн сайн мэддэг багш тогтмол цагт дэмжлэг, туслалцаа үзүүлэх Нөгөө хэлбэр нь тусгай сургалтад хамрагдаж мэргэшсэн, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий мэргэжилтэн дэмжлэг үзүүлэх 	
<ul style="list-style-type: none"> Зохицуулалт, түншлэлийн 	<ul style="list-style-type: none"> МБС, их дээд сургуулиуд, байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэр, компани, орон нутаг, эцэг эхийг оролцуулах
<ul style="list-style-type: none"> Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь сургууль төгссөний дараах боломжуудын талаар авч үздэг учраас сургуулийн зүгээс ажил мэргэжил, мэргэжлийн боловсрол, их дээд сургуулиуд, байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэр, компани, холбоодтой түншилж, хамтарч ажиллаж болно. Үүнд эцэг эхийн үүрэг хариуцлага чухал учраас үйл ажиллагааны үе шат бүрт эцэг эхтэй нягт хамтран ажиллах хэрэгтэй. 	

Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа зохион байгуулагдсаны үр дүн: Сургуулийн 12 ангийн багш та өөрийн ангийн сурагчдад багш, эцэг эх, сургуулийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүн нь дараах байдлаар харагдана. Үүнд:

- Танай ангийн сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжааны ойлголт, мэдлэг чадварт ахиц гарсан эсэх
- Танай ангийн менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт биелсэн эсэх
- Танай ангийн сурагчид өөрийн зорилготой болж бие даах чадварт ахиц гарсан байна.
- Танай ангийн сурагчдын хичээлд оролцох оролцоо сургалтын чанарт ахиц гарсан байна.
- Танай ангийн сурагчид хүссэн мэргэжлийн сургуульдаа элсэн орсон үзүүлэлт
- Танай ангийн суралцагчдын болон эцэг эхийн сэтгэл ханамжийн үзүүлэлтэд ахиц гарсан эсэх
- Танай ангийн сурагчдын хичээл сонголт оновчтой байсан эсэх, ЭЕШ-ын хэмжээт онооны үзүүлэлт
- Танай ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр ямар мэргэжил эзэмших талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Танай ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр эзэмших мэргэжлийг аль их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуульд эзэмшиж болох талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Танай ангид хичээл зааж буй багш нарын заах аргад ахиц гарсан байна.

Модуль боловсруулахад болон хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, ном зүй:
Гарын авлага:

АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

Цахим эх сурвалж:

www.myfuture.mn

<https://mergeil.mn>

<http://num.edu.mn>

<http://msue.edu.mn>

<http://rilsp.gov.mn>

<https://www.careers.govt.nz/jobs-database/>

<https://nationalcareersservice.direct.gov.uk/job-profiles/home>

<https://www.onetonline.org/find/family>

<http://hudulmur-halamj.gov.mn/occ>

<http://jobclass.ubstat.mn/>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

xxxXXXxxx

